СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2022/234-НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.selenge@audit.gov.mn<br>Сүхбаатар сум<br>2022 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас: 70363040 Цахим хаяг:<br>enkhtuyach@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 70363036 Цахим хаяг:<br>batmunkhb@audit.gov.mn<br>Аудитыг гүйцэтгэсэн: Аудитор Т.Мөнхзул<br>Утас: 70363036 Цахим хаяг:<br>Munkhzult@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт................................................3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл................................5-11
3. Аудитын тайлан................................................12
3.1 Ерөнхий зүйл................................................12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт................................................12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал................................................13
3.4 Материаллаг байдал................................................13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга................................................14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв................................................14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг................................................15
3.8 Аудитын гол асуудал................................................16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.......16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт................................................16
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал......................16
4. Аудитын илрүүлэлт................................................16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл................................................18

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |
| ШШГЕГ | Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газар |
| ШШГХ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.14 № СЭА-2022/234-НА-СТА-ТШЗ

танай ______________-ны № ______________-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭЛТСИЙН ДАРГА, ХОШУУЧ Б.ОТГОНБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

## Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| № | Балансын зүйл | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 2021 оны 1 сарын 1 | 2021 оны 12 сарын 31 |
| I | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 20,061,310.70 | 30,466,807.90 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 20,061,310.70 | 30,466,807.90 |
| 35100 | **Түүхий эд материал** | 8,512,321.00 | 14,829,516.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,870,766.00 | 14,357,721.00 |
| 35130 | Эм,боох материал | 641,555.00 | 471,795.00 |
| 35400 | **Хангамжийн материал** | 11,548,989.70 | 15,637,291.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 569,900.00 | 751,248.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,964,622.70 | 6,768,562.70 |
| 35440 | Түлш,шатах тослох материал | 130,000.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 884,500.00 | 278,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 308,294.00 | 297,520.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,691,673.00 | 7,541,461.20 |
| 36 | **НӨӨЦИЙН БАРАА** | - | - |
| II | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 368,458,222.70 | 345,406,294.35 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 368,458,222.70 | 345,406,294.35 |
| 392 | **Биет хөрөнгө** | 366,418,479.02 | 343,606,294.35 |
| 39201 | Барилга,байгууламж,орон сууц | 351,504,924.45 | 351,504,924.45 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 54,024,600.63 | 68,038,433.84 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 110,318,381.30 | 110,318,381.30 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 80,090,207.16 | 86,494,969.08 |
| 39205 | Машин,тоног төхөөрөмж (компьютер) | 60,414,299.50 | 58,577,936.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | 30,000,397.53 | 27,479,621.05 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,941,240.00 | 21,941,240.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | 13,645,160.91 | 16,723,163.43 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | 2,039,743.68 | 1,800,000.00 |
| 39301 | Программ хангамж | 7,187,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 6,947,948.63 | 6,417,692.31 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 39400 | **Бусад хөрөнгө** | - | - |
| III | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 388,519,533.40 | 375,873,102.25 |
| V | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН** | 388,519,533.40 | 375,873,102.25 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 388,519,533.40 | 375,873,102.25 |
| 51101 | Засгийн газрын оруулсан капитал | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 386,719,533.40 | 374,073,102.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 386,719,533.40 | 386,719,533.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (12,646,431.15) |
| VIII | **НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 388,519,533.40 | 375,873,102.25 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 299,879,300.00 | 328,312,683.20 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 6,928,800.00 | 13,377,983.20 |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 6,928,800.00 | 13,377,983.20 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,928,800.00 | 13,377,983.20 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,928,800.00 | 13,377,983.20 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 292,950,500.00 | 314,934,700.00 |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 292,950,500.00 | 314,934,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 292,950,500.00 | 314,934,700.00 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 321,444,210.46 | 334,414,114.35 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 321,444,210.46 | 334,414,114.35 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 316,368,427.23 | 333,728,459.31 |
| 21 | **ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ** | 238,507,186.01 | 245,669,525.36 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | 232,808,404.91 | 240,722,728.03 |
| 210101 | Үндсэн цалин | 143,491,100.00 | 152,912,429.85 |
| 210102 | Нэмэгдэл | 88,317,304.91 | 85,615,203.90 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 1,195,094.28 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,698,781.10 | 4,946,797.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,300.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,684,481.10 | 4,946,797.33 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,050,165.69 | 24,529,749.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,338,129.20 | 3,811,971.11 |
| 210302 | Түлш, халаалт | 15,757,819.49 | 15,757,819.49 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,954,217.00 | 4,959,959.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 9,199,091.00 | 11,890,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,146,450.00 | 1,231,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,621,100.00 | 5,414,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,884,300.00 | 1,783,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 61,200.00 | 60,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 446,982.00 | 490,950.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,039,059.00 | 2,909,500.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 11,459,141.57 | 13,077,932.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 500,375.00 | 626,560.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,958,766.57 | 12,451,372.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,222,413.25 | 5,799,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл | 176,000.00 | 176,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 2,046,413.25 | 5,623,100.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 270,000.00 | 200,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 270,000.00 | 200,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,674,428.00 | 1,663,924.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 504,000.00 | 866,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 254,928.00 | 184,428.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 121,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 794,500.00 | 554,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 3,596.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,986,001.71 | 30,897,928.35 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 270,000.00 | 258,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,716,001.71 | 30,639,928.35 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,075,783.23 | 685,655.04 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,900,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,900,000.00 | 200,000.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 175,783.23 | 485,655.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 175,783.23 | 485,655.04 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | - |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | -21,564,910.46 | (6,101,431.15) |
| IV | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| V | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 6,545,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 6,545,000.00 |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | -21,564,910.46 | -12,646,431.15 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2019 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (21,564,910.46) | (21,564,910.46) |
| 2020 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл | **1,800,000.00** | - | **386,719,533.40** | **388,519,533.40** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (12,646,431.15) | (12,646,431.15) |
| 2021 оын 12 сарын 31-р үлдэгдэл | **1,800,000.00** | - | **374,073,102.25** | **375,873,102.25** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссан болсон тайлан

/ төгрөгөөр /

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 292,980,550.00 | 314,934,700.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 292,980,550.00 | 314,934,700.00 |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 292,980,550.00 | 314,934,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 292,950,500.00 | 314,934,700.00 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 30,050.00 | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 290,880,550.00 | 311,246,700.00 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 290,880,550.00 | 311,246,700.00 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 285,801,766.77 | 310,561,044.96 |
| 21 | **ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ** | 238,504,943.08 | 245,669,525.36 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | 232,806,161.98 | 240,722,728.03 |
| 210101 | Үндсэн цалин | 143,491,100.00 | 152,912,429.85 |
| 210102 | Нэмэгдэл | 88,315,061.98 | 85,615,203.90 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 1,195,094.28 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,698,781.10 | 4,946,797.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,300.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,684,481.10 | 4,946,797.33 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,050,165.69 | 24,529,749.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,338,129.20 | 3,811,971.11 |
| 210302 | Түлш, халаалт | 15,757,819.49 | 15,757,819.49 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,954,217.00 | 4,959,959.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 7,993,400.00 | 8,757,848.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,166,900.00 | 1,011,048.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,367,100.00 | 5,284,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,884,300.00 | 1,783,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 61,200.00 | 60,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 513,900.00 | 618,700.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 10,366,180.00 | 12,897,398.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 396,300.00 | 456,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,969,880.00 | 12,440,598.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,175,100.00 | 16,549,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 959,000.00 | 10,770,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 176,000.00 | 176,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,040,100.00 | 5,603,100.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 270,000.00 | 200,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 270,000.00 | 200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,141,928.00 | 1,698,924.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 971,500.00 | 901,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 254,928.00 | 184,428.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 121,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 794,500.00 | 554,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 3,596.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 300,050.00 | 258,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,050.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 270,000.00 | 258,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,078,783.23 | 685,655.04 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,903,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,903,000.00 | 200,000.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 175,783.23 | 485,655.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 175,783.23 | 485,655.04 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 2,100,000.00 | 3,688,000.00 |
| 4 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | - | - |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 2,100,000.00 | 3,688,000.00 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 2,100,000.00 | 3,688,000.00 |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 2,100,000.00 | 3,688,000.00 |
| 225102 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,100,000.00 | 3,688,000.00 |
| 2260 | **Гадаад эх үүсвэрээр** | - | - |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (2,100,000.00) | (3,688,000.00) |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 314,934,700.00 | 314,449,044.96 | 485,655.04 | 99.85 |
| II | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | 314,934,700.00 | 314,449,044.96 | 485,655.04 | 99.85 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | 314,723,900.00 | 314,249,044.96 | 474,855.04 | 99.85 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 68,712,100.00 | 68,579,519.60 | 132,580.40 | 99.81 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл суутгал** | 240,813,400.00 | 240,722,728.03 | 90,671.97 | 99.96 |
| 210101 | Үндсэн цалин | 152,975,400.00 | 152,912,429.85 | 62,970.15 | 99.96 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 85,638,000.00 | 85,615,203.90 | 22,796.10 | 99.97 |
| 210103 | Унаа хоолны нэмэгдэл | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100 |
| 210104 | Урамшуулал | 1,200,000.00 | 1,195,094.28 | 4,905.72 | 99.59 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,198,400.00 | 4,946,797.33 | 251,602.67 | 95.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,198,400.00 | 4,946,797.33 | 251,602.67 | 95.16 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,534,300.00 | 24,529,749.60 | 4,550.40 | 99.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,814,000.00 | 3,811,971.11 | 2,028.89 | 99.95 |
| 210302 | Түлш, халаалт | 15,757,900.00 | 15,757,819.49 | 80.51 | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,962,400.00 | 4,959,959.00 | 2,441.00 | 99.95 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 8,759,000.00 | 8,757,848.00 | 1,152.00 | 99.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,011,300.00 | 1,011,048.00 | 252 | 99.98 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,284,800.00 | 5,284,800.00 | - | 100 |
| 210403 | Шуудан,холбоо, интернэтийн төлбөр | 1,783,000.00 | 1,783,000.00 | - | 100 |
| 210405 | Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал | 61,200.00 | 60,300.00 | 900 | 98.53 |
| 210406 | БҮТЭЗүйлс | 618,700.00 | 618,700.00 | - | 100 |
| 2105 | **Нормативт зардал** | 12,897,400.00 | 12,897,398.00 | 2 | 100 |
| 210501 | Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 456,800.00 | 456,800.00 | - | 100 |
| 210502 | Хоол хүнс | 12,440,600.00 | 12,440,598.00 | 2 | 100 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,237,600.00 | 20,237,600.00 | - | 100 |
| 210601 | Багаж,техник хэрэгсэл | 14,458,500.00 | 14,458,500.00 | - | 100 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 176,000.00 | 176,000.00 | - | 100 |
| 210604 | Урсгал засвар | 5,603,100.00 | 5,603,100.00 | - | 100 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 200,000.00 | 200,000.00 | - | 100 |
| 210702 | Дотоод албан томилолт | 200,000.00 | 200,000.00 | - | 100 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,825,800.00 | 1,698,924.00 | 126,876.00 | 93.05 |
| 210801 | Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 938,800.00 | 901,400.00 | 37,400.00 | 96.02 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 255,000.00 | 184,428.00 | 70,572.00 | 72.32 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 55,000.00 | - | 100 |
| 210806 | Мэдээлэл,технологийн үйлчилгээ | 554,500.00 | 554,500.00 | - | 100 |
| 210807 | Газрын төлбөр | 22,500.00 | 3,596.00 | 18,904.00 | 15.98 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 258,000.00 | 258,000.00 | - | 100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 258,000.00 | 258,000.00 | - | 100 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 210,800.00 | 200,000.00 | 10,800.00 | 94.88 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 210,000.00 | 200,000.00 | 10,000.00 | 95.24 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 210,000.00 | 200,000.00 | 10,000.00 | 95.24 |
| 1 | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 314,934,700.00 | 314,449,044.96 | 485,655.04 | 99.85 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 314,934,700.00 | 314,449,044.96 | 485,655.04 | 99.85 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 314,934,700.00 | 314,449,044.96 | 485,655.04 | 99.85 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | |
| 9002 | Гүйцэтгэх ажилтан | 17 | 17 | - | - |
| 9003 | Үйлчилгээний ажилтан | - | - | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн / цаашид Сайхан сум дахь ШШГХ гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сум дахь ШШГХ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сайхан сум дахь ШШГХ нь *"Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэх"* гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Сайхан сум дахь ШШГХ нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах энэхүү үүргийг бүрэн хэрэгжүүлэх,
- Цагдан хорих, таслан сэргийлэх үйл ажиллагааг хүний эрхийг дээдлэн, хүний амьдрах эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцүүлэн хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллах,
- Хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, эрүүгийн ялын зорилтыг хангах,

- Иргэний, захиргааны зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, салбар нэгжийн барилга байгууламж, ахуй нөхцөлийг сайжруулах,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлсэн дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сайхан сум дахь ШШГХ-ийн үйл ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж ажилладаг. Тухайн тайлант онд 2021 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сум дахь ШШГХ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 321,444.2 мянган төгрөгийн 1.5 хувиар буюу 4,821.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,616.2 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сайхан сум дахь ШШГХ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3.2 хувиар буюу 12,646.4 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Бараа материал | 20,061.3 | 30,466.8 | 10,405.5 |
| Үндсэн хөрөнгө | 368,458.2 | 345,406.3 | (23,051.9) |
| **Нийт хөрөнгө** | **388,519.5** | **375,873.1** | **(12,646.4)** |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 388,519.5 | 375,873.1 | (12,646.4) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **388,519.5** | **375,873.1** | **(12,646,4)** |

Бараа материалын дансны үлдэгдэл 30,466.8 мянган төгрөг болж 10,405.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр нийт 36,686.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, дээд шатны захирагчаас үнэ төлбөргүйгээр 9,478.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үйл ажиллагаандаа 35,759.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 550,560.1 мянган төгрөг болж 2,606.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 3,688.0 мянган машин тоног төхөөрөмж худалдан авсан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газраас 3,900,0 мянган төгрөгийн төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 сарын 02-ны өдрийн үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай 576 дугаар тогтоолыг үндэслэн 10,194.3 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 375,873.1 мянган төгрөг болж өмнөх оноос 12,646.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь

тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 327,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 5,038 мянган төгрөгөөр бууруулж, 321,962.0 мянган төгрөгөөр баталсан байна.

ШШГЕГ-аас батлагдсан төсөвт 2021 оны 12 дугаар сард өөрчлөлт оруулж, 7,027.3 мянган төгрөгөөр бууруулан 314,934.7 мянган төгрөгөөр эцэслэн баталсан нь Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 314,449,0 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 342.2 мянган төгрөгөөр , бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 126.8 мянган төгрөгөөр, бусад зардлыг 16.6 мянган төгрөгөөр зэрэг нийт зардлыг 485.6 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сайхан сум дахь ШШГХ нь ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны даргын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 03/1833 дугаар албан бичгээр Хорих анги,гүйцэтгэх газар хэлтсийн 4 анги салбарт суурилуулах теле хяналтын 6,545.0 мянган төгрөгийн багаж хэрэгслийн худалдан авалтыг гүйцэтгэн шилжүүлсэн бөгөөд бусад харьяа анги салбаруудаас 8,134.8 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, аж ахуйн материал үнэ төлбөргүй шилжүүлэн авч бүртгэлд тусгасан байна.

Эдгээр худалдан авалтуудын нийт төсөвт өртөг нь шууд худалдан авах босго үнээс хэтэрсэн байх эрсдэлийг үүсгэж байгаа бөгөөд харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтаас зайлсхийх зорилгоор төсөвт өртгийг хувааж, харьяа хэлтэс, хорих ангиудад худалдан авах эрхийг шилжүүлсэн байж болзошгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан,төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар "Итгэмжлэл" олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,250.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Зөвлөмж

**Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал**

1.1 <u>*Илрүүлэлт:*</u> Тайлант онд 4,250.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 <u>*Өгсөн зөвлөмж:*</u> *Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин*

*давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй"* гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ"*, гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс | 1 | 4,250.0 | | | | | | | 1 | 4,250.0 |